



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 5 дугаар
сарын 08 өдөр

Дугаар 0-101

Улаанбаатар
хот

"Улаанбаатар" телевизийн талаар авах арга хэмжээний тухай

Нэг. Монгол улсын Засгийн газрын 1994 оны 65 дугаар тогтоолоор нийслэлийн телевизийн "Өлзий" компанийн кино үйлдвэрлэх тоног төхөөрөмж, техник хэрэгслийг баримтат кино студид шилжүүлж, "Өлзий" компани нь аж ахуйн үйл ажиллагаа явуулах боломжгүй болсонтой холбогдуулан нийслэлийн телевизийн "Өлзий" компанийг "Улаанбаатар" телевиз болгон дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Нийслэлийн төр, захиргааны байгууллагын бодлого, шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, хотын олон талт амьдралын тулгамдсан асуудлын талаар чанар, үр өгөөжтэй мэдээллийг шуурхай түгээх, энэ ажилд нийслэлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн анхаарлыг төвлөрүүлж ажиллахыг "Улаанбаатар" телевиз (н.Балжжав)-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ



Нийслэлийн Засаг даргын 1997 оны
6-р тоот захирамжийн хавсралт

“УЛААНБААТАР” ТЕЛЕВИЗИЙН ДҮРӨМ

УББ 11

Нэг. Ерөнхий зүйл

1. “Улаанбаатар” телевиз нь Монгол улсын нийслэл хотын төр, захиргааны бодлого шийдвэрийг нийтлэл нэвтрүүлэгтээ тусган хэрэгжүүлэх үүрэг бүхий нийслэлийн Засаг даргын харъяа төрийн өмчийн байгууллага мөн.

Улаанбаатар хотын телевиз нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай Монгол улсын хуулийн дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрхлэх хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

2. Улаанбаатар хотын телевизийн зорилго нь нийслэлийн төр захиргааны бодлого шийдвэрийг олон түмэнд үнэн зөв, шуурхай хүргэх, нийгэм, эдийн засаг, соёл үйлчилгээний олон талт амьдрал, иргэдийн санал бодлыг тусгаж, төр, ард түмнийг холбож ажиллахад оршино.

3. “Улаанбаатар” телевизийн захирлыг нийслэлийн Засаг даргын захирамжаар томилж чөлөөлнө.

4. Нийслэлийн Засаг даргаас Улаанбаатар хотын телевизийн бүтэц зохион байгуулалтыг тогтоож, орон тоо, цалингийн санг батална.

5. “Улаанбаатар” (хойшид “телевиз” гэх) телевизийн захирал нь нийслэлийн телевизийн зорилтыг ханган биелүүлэх ажлыг нийслэлийн төр, захиргааны өмнө хариуцаж, эрх хэмжээний асуудлаар Монгол улсын төрийн хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.

6. Телевизийн захирал нь байгууллагынхаа доторхи нэгж, ажиллагчдын ажил үүргийн хуваарийг баталж мөрдүүлнэ.

7. Телевиз нь үүрэг зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх үүрэг бүхий техник уран сайхны зөвлөлтэй байна. Зөвлөлийг захирал удирдаж, бүрэлдэхүүн дүрмийг батална.

8. Телевиз нь хууль тогтоомжийн дагуу тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Телевизийн үүрэг

–Телевизийн нэвтрүүлгийн үр хийц чанарыг цаг үеийн мэдрэмжээр байнга баяжуулан үр нөлөөг сайжруулах

–Телевизийн шилдэг уран бүтээл, мэдээллийн сан байгуулж арвижуулж ажиллах.

–Телевизийн техникийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх.

–Уран бүтээлчдийн шагнал, норм норматив, нэвтрүүлгийн хөтөлбөрт ажиллагчдын шагнал, үнэ тарифийг боловсруулж нийслэлийн үнийн зөвшлийн комисст бүртгүүлж ажиллах.

–Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах зэрэг үүрэгтэй.

Гурав. “Улаанбаатар” телевизийн эрх

–Монгол улсын нийслэлийн нутаг дэвсгэрт оршиж буй бүх байгууллагад сурвалжлага хийх.

–Сурвалжлага хийх зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэр дээрх байгууллагад аж ахуйн нэгжид нэвтрэн орох.

–Нэвтрүүлэг бэлтгэхэд шаардлагатай баримт мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулж авах.

–Гадаад орны хот нийслэлд өөрийн төлөөлөгчдийг ажиллуулах асуудлыг төсөвтөө багтаан шийдвэрлэх.

–Сурвалжлах хэсэг, сурвалжлагчийг тодорхой хугацаагаар гадаадад томилон ажиллуулах.

–Гадаадын хот нийслэл болон олон улсын холбогдох байгууллагатай зохих журмын дагуу харилцаа тогтоож хамтран ажиллах.

–Бүтцийнхээ дотоодод аж ахуйн тооцоотой албан нэгж, туслах аж ахуй, үйлчилгээний цэг зохион байгуулж ажиллуулах зэрэг эрхтэй.